

# Демо арилжааны систем

ORDERBOOK.MSE.MN/DEMO

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК

## **ДЕМО АРИЛЖАА ГЭЖ ЮУ ВЭ?**

Демо буюу хийсвэр арилжаа нь бодит мөнгөөр арилжаанд оролцож эхлэхээс өмнө хийсвэр мөнгөөр арилжаанд орж, үнэт цаасны арилжаанд оролцох дадлага хийх, хөрөнгөө өсгөх арга барилаа олоход туслах арилжааны систем юм.

## **МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ДЕМО АРИЛЖААНЫ СИСТЕМ:**

Монголын хөрөнгийн биржийн демо арилжааны систем нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны бодит ханшинд тулгуурлан ажлын өдөр бүрийн 10:00 – 13:00 цагийн хооронд явагдана. Арилжаа хийхэд зориулагдсан мөнгөн үлдэгдлийн хэмжээг хэрэглэгч өөрөө тохируулах боломжтой тул хийсвэр арилжаанд та хэдэн ч төгрөгөөр арилжаа хийх боломжтой.

## **ДЕМО АРИЛЖААНЫ СИСТЕМД НЭВТРЭХ:**

1. Системд хандах: Демо арилжааны системд хандах хаяг: [orderbook.mse.mn/demo](http://orderbook.mse.mn/demo)

**2. Системд нэвтрэх:**

Хэрэв та өмнө нь Orderbook системийн хэрэглэгч бол өөрийн нэвтрэх нэр, нууц үгээр орно.

**3. Нууц үг сэргээх:**

Бүртгэлтэй хэрэглэгч нууц үгээ мартсан бол нууц үгээ и-мэйл хаягаараа баталгаажуулан сэргээх боломжтой.

1

orderbook.mse.mn/login

Захиалгын Мэдээлэл  
© Монголын хөрөнгийн бирж

2

Нэвтрэх хэсэг

Хэрэглэгчийн нэр

Нууц үг

Нэвтрэх

3

← Нууц үг сэргээх

4


Бүртгүүлэх →

**4. Системд бүртгүүлэх:**

Шинэ хэрэглэгч бол бүртгүүлэх хэсгээр орж, тодорхой мэдээллүүдийг бөглөн нэвтрэх эрх үүсгэнэ.  
*/Дэлгэрэнгүй тайлбарыг дараагийн хуудсанд/*

## ДЕМО АРИЛЖААНЫ СИСТЕМД БҮРТГҮҮЛЭХ:

- Шинэ хэрэглэгч бол бүртгүүлэх хэсгээр орж, тодорхой мэдээллүүдийг бөглөн нэвтрэх эрх үүсгэнэ.



## ДЕМО АРИЛЖААНЫ СИСТЕМИЙН ТАНИЛЦУУЛГА:

**1. Хэрэглэгч:** Хэрэглэгчийн бүртгүүлсэн овог, нэрийг харуулна.

**2. Бэлэн мөнгөний үлдэгдэл:** Демо арилжааны мөнгөн үлдэгдлийг харуулна.

**3. Мөнгө нэмэх:** Тус товчин дээр дарж демо арилжаанд оролцох өөрийн хүссэн хэмжээний мөнгөн дvнг нэмнэ.

**4. Дансны үлдэгдэл:** “Мөнгөн үлдэгдэл” болон “Хувьцааны үлдэгдлийн тоо ширхгийг сүүлийн өдрийн хаалтын ханшаар үржүүлсэн үнийн дvн”-гийн нийлбэр.

**5. Үнэт цаасны үлдэгдэл:** Дансанд байгаа үнэт цаасны үлдэгдлийг тоо ширхгээр болон хамгийн сүүлд хэлцэл хийгдсэн ханшаар тооцсон мөнгөн дvнгээр илэрхийлж харуулна.

**6. ХК-ийн хайлт :** Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаасны компаниудыг хоёрдогч зах зээлийн арилжааны идэвхээр эрэмбэлж, бодит арилжааны системийн сүүлийн ханшийг харуулна.

- Хувьцаат компаниудын жагсаалтаас хувьцааны нэр болон үсгэн кодоор хайх боломжтой.
- Сонгосон хувьцаат компани дээр дарахад түүний ханшийн график, захиалгын дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

**Демо арилжаа**  
 Бэлэн мөнгөний үлдэгдэл: 1,210.50 ₮  
 Захиалга  
 Дансны шинжилгээ

Хайх

Нүүр хуудас

**1** Хэрэглэгч: **Нэр Овог**

**2** Бэлэн мөнгөний үлдэгдэл: **1,210.50₮**

**3** Мөнгө нэмэх

**4** Дансны үлдэгдэл: **16,460.50₮**

**5** Үнэт цаасны үлдэгдэл

| № | Үнэт цаасны симбол | Тоо ширхэг | Мөнгөн дvнгээр |
|---|--------------------|------------|----------------|
| 1 | HGN                | 100        | 9000₮          |
| 2 | ITLS               | 50         | 6250₮          |

LEND-O-0000 70.57 [0.61%]  
ЛэндМН ББСБ ХК

AIC-O-0000 899.48 [0.06%]  
Ард Даатгал ХК

ERDN-O-0000 591.63 [-1.97%]  
Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК

UID-O-0000 529 [-5.48%]  
Улсын их дэлгүүр ХК

ITLS-O-0000 125 [-3.6%]  
Айтүүлс ХК

APU-O-0000 571.94 [-0.16%]  
АПУ ХК

MNP-O-0000 555 [0%]  
Монгол шуудан ХК

MBW-O-0000 366.77 [-1.85%]  
Монгол Базальт ХК

HGN-O-0000 90 [2.22%]  
Хөх ган ХК

JIV-O-0000 1824 [0.88%]  
Жинст-Увс ХК

GOV-O-0000 33080 [2.12%]  
Говь ХК

TTL-O-0000 7715 [-0.78%]  
Таван толгой ХК

SHV-O-0000 2000 [0%]

## ДЕМО АРИЛЖААНЫ СИСТЕМ – ЗАХИАЛГА ӨГӨХ:

- Демо арилжааны системд дараах байдлаар захиалга өгнө. Энэ нь бодит арилжааны системийн загварчилсан хувилбар тул захиалгын нөхцөлүүд Монголын хөрөнгийн биржийн арилжааны нөхцөлтэй ижил байна.

**Захиалга өгөх**

Дэлгэрэнгүй

1. **Хувьцаат компани:** Захиалга өгөх хувьцаагаа сонгоно.

2. **Авах/Зарах:** Авах, зарах захиалгын төрлийг сонгоно.

3. **Захиалгын төрөл:**  
**Нөхцөлт захиалга** – Нөхцөлт захиалга гэж хувьцаа авах үнийн дээд түвшин, эсхүл зарах үнийн доод түвшинг заасан захиалгыг ойлгоно. Мөн худалдах, авах хувьцааны тоо ширхгийг тодорхой зааж өгнө. Зөвхөн тухайн үнийн түвшинд хүрсэн тохиолдолд биелэх боломжтой байна. Бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар биелж болно.  
**Зах зээлийн захиалга** – Хувьцааг авах эсхүл зарах ханш хэд байсан ч хамаагүй тухайн үеийн зах зээлийн ханшаар захиалгаа баталгаатай биелүүлэх сонирхолтой үед энэ захиалгын төрлийг ашиглана. Энэ захиалгыг ашиглахдаа үнэ нь тодорхойгүй, харин авах эсхүл зарах хувьцааны тоо ширхгийг хэрэглэгч тогтоож өгнө. Бүрэн биелээгүй тохиолдолд биелээгүй үлдсэн хэсэг нь хүчингүй болно.

4. **Биелэх нөхцөл:** Захиалгын хүчинтэй хугацааг сонгох  
**Захиалга хийсэн өдөр** – Зөвхөн захиалга хийсэн өдрөө хүчинтэй.  
**Заасан өдөр хүртэл** – 30 хүртэлх өдрийн дотор таны заасан өдөр хүртэл хүчинтэй байна.  
**Цуцлагдах хүртэл** – 30 хүртэлх өдрийн дотор цуцлах хүртэлхүчинтэй байна.

5. **Хүчинтэй хугацаа:** “Заасан өдөр хүртэл” гэсэн захиалгын нөхцөлийг сонгосон тохиолдолд захиалгын хүчинтэй байх өдрийг сонгоно.

6. **Хэмжээ:** Захиалга өгөх хувьцааны тоо ширхгийг оруулна.

7. **Нэгжийн үнэ:** Нөхцөлт захиалгын төрлийг сонгосон тохиолдолд авах, зарах захиалгын нэгжийн үнийг оруулна.


Болих Захиалга өгөх

# ДЕМО АРИЛЖАА – ЗАХИАЛГЫН САН:

**1. Хувьцаат компани:** Захиалга өгөх хувьцаагаа сонгоно. /mouse 1-ийг хоёр удаа дарна/

**2. Ханшийн ерөнхий мэдээ:** Сонгосон хувьцааны ерөнхий мэдээг харуулна. /Нээлтийн ханш, Дээд ханш, Доод ханш, Сүүлийн хэлцэл хийгдсэн ханш, Өмнөх өдрийн хаалтын ханш, Өнөөдрийн өөрчлөлт/

**3. Дахин ачаалах:** Тухайн хуудсан дахь мэдээллийг “Дахин ачаалах” товчоор шинэчилнэ. Тус товчийг дарахгүй бол мэдээлэл шинэчлэгдэхгүй болохыг анхаарна уу !!!



**6. Миний захиалга:** Таны оруулсан бүх хүчинтэй захиалга тус самбарт тогтмол харагдана.

- Цэнхэр өнгийн захиалга: Идэвхтэй буюу биелэгдээгүй захиалга. Та энэ захиалгаа өөрчилж, мөн цуцалж болно.
- Ногоон өнгийн захиалга: Биелсэн захиалгыг харуулна.

**4. График:** Захиалгын сангийн график нь таны сонгосон хувьцааны нээлт, хаалтын ханш, тухайн өдөр арилжигдсан ханшийн дээд, доод түвшинг харуулна. Тухайн өдрийн арилжааны туршид хувьцааны ханш өсөх, буурах хэлбэлзэл нь өмнөх өдрийн хаалтын ханшаас 15 хувиас илүүгүй байна. Мөн тус графикийг Лаан /Candle/ график болон Шугаман /Line/ графикаар харах боломжтой.

**5. Захиалгын сан харах:** Бодит арилжааны систем дэх авах/зарах захиалгын сангийн мэдээллийг хугацаагаар эрэмбэлэн харуулна. **Захиалгын санд таны оруулсан демо арилжааны захиалга бодит арилжааны захиалгууд дунд орж харагдана.** Захиалга биелээгүй бол цуцлах хүртэл захиалгын санд хадгалагдан үлдэнэ. **Биелсэн хэлцэл:** Захиалгын сангаас биелэгдсэн захиалгуудын хэлцлийн мэдээллийг хугацаагаар эрэмбэлэн харуулна.

**5 Захиалгын сан харах**

| Авах захиалга |                 | Биелсэн хэлцэл      |            | Зарах захиалга |           |                  |
|---------------|-----------------|---------------------|------------|----------------|-----------|------------------|
| Авах үнэ      | Авах тоо ширхэг | Огноо               | Тоо хэмжээ | Ханш           | Зарах үнэ | Зарах тоо ширхэг |
| 72.00         | 3,500           |                     |            |                | 74.98     | 6,000            |
| 72.00         | 2,000           | 2018-10-08 12:56:59 | 477        | 74.00          | 75.00     | 16,238           |
| 71.61         | 4,211           | 2018-10-08 12:55:41 | 120        | 74.00          | 75.00     | 5,099            |
| 71.61         | 20,989          | 2018-10-08 12:55:41 | 16,803     | 74.00          | 75.00     | 10,000           |
| 71.50         | 34              | 2018-10-08 12:55:41 | 16,803     | 74.00          | 75.00     | 25,360           |
| 71.00         | 8,000           | 2018-10-08 12:55:41 | 16,803     | 74.00          | 75.00     | 46,281           |
| 70.00         | 14,990          | 2018-10-08 12:54:22 | 2,154      | 73.50          | 75.99     | 600              |
| 67.60         | 20,961          | 2018-10-08 12:54:22 | 2,154      | 73.50          | 76.00     | 130,000          |
| 67.50         | 2,570           | 2018-10-08 12:53:36 | 13,000     | 73.50          | 80.00     | 15,512           |
| 66.00         | 67,830          | 2018-10-08 12:53:36 | 3,880      | 73.50          | 80.00     | 1,666            |

## ДЕМО АРИЛЖААНЫ СИСТЕМ – ЗАХИАЛГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ:

**1. “Таны захиалга” хайлтын хэсэг:** Захиалгууд үнэ болон цаг хугацааны дарааллаар эрэмбэлэгдэх ба захиалга биелэгдэхээс өмнө захиалгыг өөрчлөх, цуцлах боломжтой байна.

Мөн захиалгыг дараах төрлүүдээр хайлт хийх боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны нэр, үсгэн код
- Худалдан авах, худалдах төрөл
- Захиалгын төлөв: Идэвхтэй, Биелсэн, Цуцалсан, Захиалгын хугацаа дуусаж цуцлагдсан, Хагас биелсэн.
- Захиалгын хүчинтэй хугацаа гэх мэтээр хайлт хийх боломжтой.

**2. Дахин ачаалах:** Тухайн хуудсан дахь мэдээллийг “Дахин ачаалах” товчоор шинэчилнэ. Тус товчийг дарахгүй бол мэдээлэл шинэчлэгдэхгүй болохыг анхаарна уу !!!

Нүүр хуудас

### Таны захиалга

Бүгд Бүгд Бүгд 2018-10-08 2018-10-08 Хайх

| № | Захиалгын дугаар | Үнэт цаасны симбол | Төлөв    | Авах / Зарах | Хэмжээ | Нэгжийн үнэ | Огноо               | Үйлдэл            |
|---|------------------|--------------------|----------|--------------|--------|-------------|---------------------|-------------------|
| 1 | 1811163241       | ITLS               | Идэвхтэй | Авах         | 100    | 125.00      | 2018-10-08 10:39:16 | Өөрчлөх<br>Цуцлах |
| 2 | 1625700972       | ITLS               | Биелсэн  | Авах         | 50     | 126.50      | 2018-10-08 10:38:34 |                   |
| 3 | 1068445750       | HGN                | Биелсэн  | Авах         | 100    | 94.00       | 2018-10-08 10:37:43 |                   |

**3. Захиалгын дэлгэрэнгүй:** Хайлтын хэсгээс та өөрийн оруулсан захиалгын түүхийг үүсгэн дараах төрлүүдээр харах боломжтой.

**№1: Захиалгын төлөв: Идэвхтэй** - Цэнхэр өнгийн захиалга нь идэвхтэй буюу биелэгдээгүй захиалга. Та энэ захиалгыг өөрчилж, мөн цуцлах боломжтой.

**№2: Захиалгын төлөв: Биелсэн** - Ногоон өнгийн захиалга нь таны захиалга амжилттай биелсэнийг харуулна.

Таны оруулсан захиалга системд бүртгэгдсэн тухай болон биелэгдсэн эсэхийг өнгөөр ялган харуулах болно.

Захиалгын дугаар дахин давтагдашгүй бөгөөд таны захиалгыг хэсэгчлэн, эсхүл бүхэлдээ биелэгдсэнийг хянах боломжийг бүрдүүлнэ.



## ДЕМО АРИЛЖААНЫ СИСТЕМ – ДАНСНЫ ШИНЖИЛГЭЭ:

- Дансны шинжилгээ нь хувьцааны дансан дахь үлдэгдлийн дэлгэрэнгүй мэдээлэл, түүний ашиг алдагдал, үнэ цэнийг харуулна. Таны хувьцааны үлдэгдлийг сүүлийн хаалтын ханшаар тооцсон дүн дээр арилжааны шимтгэлийн үнийн дүнг нэмж харуулна.

| Дансны шинжилгээ |                       |            |             |                   |            |              |                  |                   |
|------------------|-----------------------|------------|-------------|-------------------|------------|--------------|------------------|-------------------|
| №                | Үнэт цаасны нэр       | Хэмжээ     | Нэгжийн үнэ | Нийт              | Үлдэгдэл   | Хаалтын ханш | Шимтгэл          | Ашиг / алдагдал   |
| 1                | LEND - ЛэндМН ББСБ ХК | 61         | 63.92       | 3,898.94          | 61         | 61.64        | 75.20            | -292.08           |
| 2                | APU - АПУ ХК          | 600        | 591.00      | 354,600.00        | 600        | 573.14       | 6,877.68         | -24,685.68        |
| 3                | TTL - Таван толгой ХК | 60         | 8,250.00    | 495,000.00        | 60         | 7,795.00     | 9,354.00         | -46,554.00        |
| 4                | SUU - Сүү ХК          | 100        | 222.00      | 22,200.00         | 100        | 228.00       | 456.00           | -300.00           |
|                  | <b>Нийт</b>           | <b>821</b> |             | <b>875,698.94</b> | <b>821</b> |              | <b>16,762.88</b> | <b>-71,831.76</b> |

- I. Үнэт цаасны нэр:** Таны дансны үлдэгдэл хувьцааны нэр, үсгэн код
- II. Хэмжээ:** Худалдан авсан хувьцааны хэмжээ
- III. Нэгжийн үнэ:** Дансан дахь хувьцааны анх худалдан авсан үнэ.
- IV. Нийт:** Хувьцаа анх худалдан авсан нийт үнэ
- V. Үлдэгдэл:** Тухайн хувьцааны үлдэгдэл тоо ширхэг
- VI. Хаалтын ханш:** Арилжааны өдрийн 13 цаг 05 минутаас өмнө өмнөх өдрийн хаалтын ханшийн мэдээлэл, 13 цаг 05 минутаас хойш тухайн өдрийн өдрийн хаалтын ханшийг харуулна.
- VII. Шимтгэл:** Үлдэгдэл хувьцааг хаалтын ханшаар үржүүлсэн үнийн дүнгээс тооцсон арилжааны шимтгэл. Арилжааны шимтгэлийг арилжааны үнийн дүнгийн тогтмол **2%**-иар тооцов. /Жишээ №1/
- VIII. Ашиг алдагдал:** Таны данс дахь хувьцааг сүүлийн хаалтын ханшаар буцаан зарахад арилжааны шимтгэлийн зардлыг оруулан гарч болох ашиг/ алдагдлын хэмжээг харуулна. / Жишээ №2/

**Жишээ №1:** Та “Сүү” ХК /SUU/-ийн 100 ширхэг хувьцаа эзэмшдэг гэвэл одоогийн хаалтын ханш буюу 228 төгрөгөөр худалдвал нийт  $228 \times 100 \text{₮} = 22800 \text{₮}$  -ний арилжаа хийж, таны **арилжааны шимтгэл**  $22800 \text{₮} \times 0,02 = 456 \text{₮}$  болно.

$$\text{Арилжааны шимтгэл} = (\text{хэмжээ}(V) \times \text{зарах ханш}(VI)) \times 0.02$$

**Жишээ №2:** Та “Сүү” ХК /SUU/-ийн хувьцааг анх авахдаа нэгжийн үнийг 222 төгрөгөөр 100 ширхгийг нийт 22,200 төгрөгөөр авсан ба  $22,200 \text{₮} \times 0,02 = 444 \text{₮}$  төгрөгний шимтгэл төлж нийт  $22,200 \text{₮} + 444 \text{₮} = 22,644 \text{₮}$  төгрөгийн арилжаа хийсэн. Хэрэв та жишээн дэх хаалтын ханш болох 228 төгрөгөөр 100 ширхгийг  $22,800 \text{₮}$ -өөр зарсан бол арилжааны шимтгэл  $22,800 \times 0,02 = 456 \text{₮}$  болж, цэвэр дүнгээр  $22,800 \text{₮} - 456 \text{₮} = 22,344 \text{₮}$  авна. Таны арилжааны ашиг/ алдагдлыг арилжааны шимтгэлийг оруулан тооцвол  $22,344 \text{₮} - 22,644 \text{₮} = -300 \text{₮}$  болж байна.

$$\text{Ашиг/алдагдал} = (\text{үлдэгдэл}(V) \times \text{зарах ханш}(VI)) \times 1.02 - (\text{хэмжээ}(V) \times \text{зарах ханш}(VI)) \times 0.98$$